

## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2024 оны 12 сарын 06 ний өдөр

Дугаар 10224/22

Улаанбаатар хот

### Нэг. Удиртгал хэсэг

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан "Буянт-Ухаа спортын ордон"-ын барилга байгууламжид Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 68/А/74 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 17 гишүүний бүрэлдэхүүнтэй хурал 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

### Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний огноо: 2006/07/27 ны өдрийн 362 дугаарт: Барилгын байршлыг тогтоож, газар эзэмшүүлэх эрх олгох тухай

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: №TG-106-06 шифрийн дугаартай ерөнхий төлөвлөгөө, гадна цэвэр, бохир ус,

- "Элста" ХХК-ийн 11-06 шифрийн дугаартай гадна цахилгаан хангамжийн зураг
- "Сан Проект" ХХК-ийн СП15-2006 шифрийн дугаартай гадна дулааны зураг
- "China International Engineering Design and Consulting" Co.,LTD-ийн боловсруулсан 0601 шифрийн дугартай а. Архитектурын зураг , б .Барилгын бүтээц, в. Шугам сүлжээний зургууд

2.3. Захиалагч:

"Монгол Улсын Биеийн тамир, спортын Улсын хороо"

Хаяг: Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан "Буянт-Ухаа спортын ордон"-ын барилга;

Холбоо барих утас: 976-11-321002 ,976-11-263696, цахим хаяг: @gmail.com

2.4. Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч:

"Шанхай Констракшн" Групп;

Хаяг: 107 Янган рөүд, Шанхай , Хятад Улс;

Утас: 86-21 63720265, Факс: 86-21 63722783.

2.5. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага:

"Ти энд Жи" ХХК

Хаяг: Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, UB таувер, 1308 тоот;

Холбоо барих утас: 7711 3500, цахих хаяг: info@tg.mn.

2.6. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:

"Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв" ТӨААТҮГазар, регистрийн дугаар;

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн баруун бүс  
17071 Ажилчны гудамж 74-1 тоот;  
Холбоо барих утас: 7018-7520 ,70179473 цахим хаяг: info@trainingcenter.mn.

2.7. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан.

### Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

○ Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын 2006 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр солилцсон захидал, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлийг үндэслэн:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

-Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан "Буянт-Ухаа спортын ордон"-ын барилга байгууламжид Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын хамтарсан 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 68/А/74 тоот тушаалаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 17 гишүүний бүрэлдэхүүнтэй хурал 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг



НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 10 ДУГААР ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАРИГДСАН "БУЯНТ-УХАА СПОРТЫН  
ОРДОН"-ЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ  
дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

#### **Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт**

4.1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан "Буянт-Ухаа спортын ордон"-ын барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Комиссын дарга:

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын  
яамны Барилга, барилгын материалын бодлого,  
зохицуулалтын газрын дарга



Д.Гантулга

Комиссын нарийн бичгийн дарга:

"Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв"  
ТӨААТҮГ-ийн маркетинг мэргэжилтэн

Д.Болорсайхан